



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 30 өдөр Дугаар 28

Хэрлэн сум

ХХIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. KOICA байгууллагаас аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн хүсэлтийг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүх,

2. Коронавируст халдвартай тэмцэх ажилд аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс өгч буй хандив тусламжийг зохицуулах талаар чиглэл хүсч аймгийн Засаг даргаас Авилгатай тэмцэх газарт явуулсан алба бичгийн хариу ирснийг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүх,

3. Аймгийн иргэдээс БНХАУ-д зорчих хүсэлт ирснийг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүх,

4. Хэрлэн сумын хог цэвэрлэгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн хүсэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Эрдэнэбаяр,

5. Аймгийн Засаг даргын захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх баар, караоке, дэн буудлын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосныг сунгах эсэх талаар Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

6. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтын талаарх саналыг Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Хөлөнбуйр сум,

7. Цэвэр ус хангамжийн алба, худгийн харуул хамгаалалт, аюулгүй байдлын талаар "Дорнод НАА" ОНӨААТҮГ, Цагдаагийн газрын Дотоодын цэрэг,

8. Махны захууд иргэдэд амны хаалт, бээлий, хормогчгүй үйлчилж байна гэж иргэдээс гомдолыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүх,



9.Баянхошуу боомтын ариутгал, халдваргүйтгэлийн функтыг камерын хяналттай болгох асуудлаар Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа нарын мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

1.1.Аймгийн нэр бүхий иргэдээс аймгийн Онцгой комиссын даргад ирүүлсэн БНХАУ-д зорчих хүсэлтийг Улсын Онцгой комисст уламжлан шийдвэрлүүлэх тухай албан бичиг хүргүүлэхийг,

Хоёр.Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Эрдэнэбаяр, "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-ын дарга Б.Тэгшжаргал, сумын Засаг дарга нарт:

2.1.Хог хаягдал цэвэрлэх ажлыг бүх нийтийн хэмжээнд зохион байгуулах санал, төлөвлөгөөг танилцуулж шийдвэр гаргуулахыг,

2.2.Голын ай, сав газрын ойролцоох сум, баг, иргэд олон нийтийг хог хаягдал цэвэрлэх ажилд оролцуулж, аймгийн Засаг даргын 2020 оны А/180 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг,

Гурав.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг-д:

3.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх баар, караоке, дэн буудал, компьютерын тоглоомын газар /РС/, билльярд, спорт заалны үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаагаар зогсоох шийдвэрийн төслийг танилцуулахыг,

Дөрөв. Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

4.1.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Тагнуулын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газруудаас бүрдсэн ажлын хэсгийг байгуулан "Дорнод НАА" ОНӨААТҮГ-ын Цэвэр ус хангамжийн алба, худгуудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж танилцуулахыг,

4.2.Цэвэр ус хангамжийн албаны хашааг шинэчлэх ажлыг түргэвчлэхийг,

Тав.Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтын 5 цэгт ажиллах алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор даавуун амны хаалт 300 ширхэг, санитол 500мл-тэй 5 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг,

5.2.Шуурхай ажиллагааг хангах зорилгоор аймгийн Онцгой комисст материаллаг хандиваар ирсэн хэт богино долгионы гар станцаас Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газарт 7 ширхэг, аймгийн Засаг даргын Тамгын газарт 3 ширхэгийг тус тус олгож шийдвэрлэхийг,



5.3.Хөлөнбуйр сумын хяналтын цэгт ажилласан төрийн албан хаагчдын хоолны зардал болох 228,900 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг,

5.4.Баянтүмэнгийн гүүрний хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй /Цагдаагийн газар, ГИХГ/ 2 албан хаагчийн хоолны зардал болох 600,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг,

5.5.Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх зорилгоор зайнаас халуун хэмжигч багажийг Эрүүл мэндийн газарт 10 ширхэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд 10 ширхэг, Мэргэжлийн хяналтын газарт 5 ширхэгийг тус тус худалдан авах хөрөнгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг,

Зургаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

6.1.Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг орон нутгийн телевизүүдээр иргэдэд хүргэх хуваарийг гаргах, олон нийтэд мэдээллийг тасралтгүй хүргэж байх тухай албан бичгийг орон нутгийн телевизүүдэд хүргүүлж ажиллахыг,

6.2.Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Халдвартын тасагт тусгаарлан ажиглагдаж байгаа 0-5 насны 3 хүүхдийн тусгаарлан ажиглах байрны зардлыг чөлөөлөхийг,

Долоо.Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.1.Шүүхийн шийдвэрээр улсын орлого болгохоор шийдвэрлэгдсэн 4 ширхэг автомашиныг хот, аймаг, сум хоорондын автозамд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор засварлаж байршуулахыг,

Найм.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтүяа-д:

8.1.Иргэдээс ирсэн гомдлын дагуу махны захуудын түрээслэгч нарын эрүүл ахуй, халдвар хамгааллын хувцас хэрэгсэлд хяналт тавин зөрчлийг арилгуулж танилцуулахыг,

8.2.Хилийн боомтуудад ариутгал, халдваргүйтгэлийн пунктыг камержуулахыг тус тус үүрэг болголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА